

# **Санхүүгийн тайлан бэлтгэх нь**

П.Жаргалтуяа /Доктор(Ph.D), дэд профессор/

## Агуулга:

- 1. Санхүүгийн байдлын тайлан*
  - 2. Орлогын дэлгэрэнгүй тайлан*
  - 3. Өмчийн өөрчлөлтийн тайлан*
  - 4. Мөнгөн гүйлгээний тайлан*
- Санхүүгийн тайлангийн тодруулга орно.*
- Дасгал ажил, кэйс*

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

Санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн нь хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, өр төлбөрөөс бүрдэнэ. Нийт хөрөнгийг эргэлтийн хөрөнгө, эргэлтийн бус хөрөнгө гэж ангилна.

- **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.** Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна.
- **Дансны авлага.** Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас нэхэмжлэж буй дүн. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгө хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.
- **Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага.** ААНОАТ, НӨАТ, бусад татвар, төлбөр, хураамж болон НДШ-ийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

- **Бусад авлага.** Бусад байгууллага, хувь хүн, харилцан холбоотой талд өгсөн, нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.
- **Бусад санхүүгийн хөрөнгө.** Үүнд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна.
- **Бараа материал.** Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.
- **Урьдчилж төлсөн зардал/тооцоо.** Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлага (даатгал, түрээс г.м) юм. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.
- **Бусад эргэлтийн хөрөнгө.** /Эргэлтийн биологийн болон бусад.../
- **Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө.** *СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа – д заасны дагуу бүртгэнэ.*

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

Эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилна:

- **Үндсэн хөрөнгө.** Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө хамаарна/ Газрын сайжруулалт, Барилга байгууламж, Машин тоног төхөөрөмж, Тээврийн хэрэгсэл, Тавилга эд хогшил, Компьютер, бусад хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө/. Үндсэн хөрөнгийн дахин үнэлэх үед хүлээн зөвшөөрөгдсөн орлогыг Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэнэ.
- **Үндсэн хөрөнгийн элдэгдэл.** Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг шулуун шугамын аргаар тооцоно. /ААНОАТ-ын тухай хууль, 13.2/
- **Биет бус хөрөнгө.** Биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгө. Биет бус хөрөнгийг тайланд хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр бүртгэнэ. /Зохиогчийн эрх, Патент, Компьютерийн програм хангамж, мэдээллийн сан, Барааны тэмдэг, Тусгай зөвшөөрөл, Газар эзэмших эрх, бусад биет бус хөрөнгө: *барилгын зураг төсөл, ТЭЗҮ ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал*/. Анхны өртөг эсвэл дахин үнэлгээгээр бүртгэнэ. Ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар, аш.хугацаагүй бол хорогдуулахгүй.

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

Эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилна:

- **Биологийн хөрөнгө.** ХАА үйл ажиллагаа эрхэлдэг, өсч, үржиж, үр жимс үр төлөө өгдөг амьд амьтан ургамал зэргийг биологийн хөрөнгөөр бүртгэнэ.
- **Урт хугацаат хөрөнгө оруулалт.** Мөнгөтэй адилтгах хөрөнгө ба БХХО-д хамаарагдахгүй бусад бүх хөрөнгө оруулалт юм. Урт хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх, Тусгай зориулалтаар байгуулсан сангаарх хөрөнгө оруулалт, Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө */ирээдүйд үнэ өсөхөд худалдахаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө/* орно.
- **Хайгуул ба үнэлгээний хөрөнгө.** Аж ахуйн нэгж ямар зардлуудыг */хайгуулын бэлтгэл ажил, геологи, геохими, геофизикийн судалгаа өрөмдлөг, малталт хийх, дээж авах, ТЭЗҮ холбоотой зардлууд/* хайгуул, үнэлгээний хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхийг СТОУС-6, Сангийн сайдын 2011 оны 12 тоот тушаал, журмаар бүртгэнэ.
- **Хойшлогдсон татварын хөрөнгө.** Ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн.
- **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө.** Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох зорилгоор эзэмшиж буй хөрөнгө.
- **Бусад эргэлтийн хөрөнгө:** Урт хугацаат зээлийн авлага, бусад

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

**Өр төлбөр:** Богино хугацаат өр төлбөр /Үйл аж 1 цикл, 1 жил дотор/, Урт хугацаат өр төлбөр

- **Дансны өглөг.** Бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан, хангамжийн зүйлс, үйлчилгээний төлөгдөөгүй дүн.
- **Цалингийн өглөг,** Татварын өглөг, НДШ-ийн өглөг, Богино хугацаат зээл, Хүүний өглөг, Ногдол ашгийн өглөг, Урьдчилж олсон орлого, Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр.
- **Нөөц (Өр төлбөр).** Баталгаат засварын өр, нөхөн сэргээлт, болон бусад болзошгүй өр төлбөртэй холбоотойгоор байгуулсан нөөцийн дүнг тодруулна. Урт болон богино хугацаанд хамаарна.
- **Хойшлогдсон татварын өр.** Хойшлогдсон татварын хөрөнгөтэй холбоотой ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өр.
- **Эздийн өмч:** Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч, өмчийг хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ.
- **Халаасны хувьцаа.** Энэ нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч, эргэлтэнд байгаа хувьцааны тоонд орохгүй. Олз, гарзыг хүлээн зөвшөөрөхгүй.

# 1. Санхүүгийн байдлын тайлан /Баланс/

- **Нэмж төлөгдсөн капитал.** Энгийн болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс өндөр байвал зөрүүг НТК дансанд бүртгэнэ.
- **Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл.** Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд бүртгэнэ.
- **Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц.** Гадаад валют хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг бүртгэнэ.
- **Эздийн өмчийн бусад хэсэг.** Дэлгэрэнгүй орлогын тайлангаар хүлээн зөвшөөрсөн олз, гарзыг бүртгэнэ.

Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
Хөрөнгө	
Эргэлтийн хөрөнгө	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	34,250
Дансны авлага	135,000
Бараа материал	189,000
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	13,500
Эргэлтийн хөрөнгийн дүн	371.750
Үндсэн хөрөнгө	427,500
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	427,500
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>799.250</b>
Б. Өр төлбөр ба эзний өмч	
Дансны өглөг	78,750
Татварын өр	49,500
Хүүний өглөг	6,750
Богино хугацаат өр төлбөрийн дүн	135.000
Бусад урт хугацаат өр төлбөр - Бондын өглөг	202,500
УХӨТ-ийн дүн	202,500
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>337.500</b>
Эздийн өмч	
Энгийн хувьцаа	162,500
Халаасны хувьцаа	(4,000)
Нэмж төлөгдсөн капитал	51,250
Хуримтлагдсан ашиг	252,000
Эздийн өмчийн дүн	461.750
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>799.250</b>

## 2. Орлого тооцоололт, орлогын дэлгэрэнгүй тайлан

Орлого нь аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагааны явцад бий болсон үр дүн, эдийн засгийн өгөөж юм. Үндсэн үзүүлэлтийг орлого, зардал, олз, гарз гэж ангилна. Орлогыг аккруэл сууриар бүртгэнэ. Орлогод: Борлуулалтын орлого, түрээсийн орлого, хүүний орлого, ногдол ашиггүйн орлого, эрхийн шимтгэлийн орлого, хандивийн орлого орно. Орлогын бүртгэл:

дб	Мөнгөн хөрөнгөн/ Дансны авлага/ хүүний авлага	xxx
кр	Борлуулалтын орлого/ хүүний авлага/	xxx

Орлогын тайланг 2 хэлбэрээр бэлтгэнэ.

1. Нэг үе шатат орлогын тайлан. Цэвэр ашиг, алдагдлыг тооцохдоо нэг л удаа хасах үйлдэл хийдэг.
2. Олон үе шатат орлогын тайлан. Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг дэлгэрэнгүй, зардлыг хураангуй тайлагнадаг. Орлогыг хүлээгдэж буй бодит үнэ цэнээр, зардлыг чиг үүргээр нь ангилж, үр дүнг тооцно. Зардлыг Борлуулалтын өртөг /ББӨ/, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт ба маркетингийн зардал, санхүүгийн зардал, бусад зардал, орлогын татварын зардал гэж ангилан тайлагнана. Үр дүн буюу ашгийг Нийт ашиг, ТӨА, ТДЦА алдагдал, тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/, зогсоон үйл ажиллагааны ашиг/алдагдал/ нэгж хувьцаанд суурь ногдох ашиг, алдагдлыг тооцно. Олз, гарзыг бүртгэнэ. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, /гарз/ , үндсэн хөрөнгө, биет бус данснаас хассаны олз, /гарз/, хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/ ангилан тайлагнана.

дб	Ерөнхий удирдлага/ борлуулалт, маркетингийн зардал/ Санхүүгийн зардал/ ОТЗ	xxx
кр	Мөнгөн хөрөнгө/ Өглөг/ хүүний өглөг	xxx

## 2. Орлого тооцоололт, орлогын дэлгэрэнгүй тайлан

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд: Орлого

- **Борлуулалтын цэвэр орлого.** Борлуулалтын орлогоос борлуулалтын хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын үнийн бууралтыг хассан цэвэр орлого.
- **Борлуулалтын буцаалт:** Бараа бүтээгдэхүүний гологдол, гэмтэл, захиалгын шаардлага хангаагүй шалтгаанаар худалдан авагчийн буцаасан борлуулалтыг “Борлуулалтын буцаалт” дансанд бүртгэнэ.
- **Борлуулалтын хөнгөлөлт:** Зээлээр худалдан бараа, бүтээгдэхүүний үнийг хугацаанд нь багтааж төлсөн үед үзүүлж буй хөнгөлөлт. Тухайлбол: 2/10, n/30
- **Түрээсийн орлого:** Хөдлөх, үл хөдлөх хөрөнгөө бусдад ашиглуулах буюу түрээслүүлэн олж буй орлого
- **Хүүний орлого:** Мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлбөр буюу харилцах дансны үлдэгдэлд авч буй хүү, мөнгөн хөрөнгийн хадгамж, бондын хүү
- **Ногдол ашгийн орлого:** Хувь нийлүүлсэн ААН-ээс ашиг хуваах буюу хувь хүртэх хэлбэрээр авсан мөнгөн болон мөнгөн бус орлого.
- **Эрхийн шимтгэлийн орлого:** ААН-ээс барааны тэмдэг зохиогчийн эрх, патент зэрэг биет бус хөрөнгө ашиглуулсны төлөө бусдас авсан орлого.
- **Бусад орлого:** Татаас, санхүүжилтын орлого, алданги, торгуулийн орлого, хандив тусламж, туслах үйлдвэрлэлийн, даатгалын нөхөн олговор, татварын буцаалт зэрэг орлого багтана.

## 2. Орлого тооцоололт, орлогын дэлгэрэнгүй тайлан

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд: Зардал

- **Санхүүгийн зардал:** Бүх төрлийн хүүний зардал, зээлийн шимтгэл, зээлтэй холбоотой үүссэн бусад зардал.
- **Бусад зардалд:** Маркетинг борлуулалт болон ерөнхий удирдлагын зардалд ороогүй хандив, алданги, торгууль, банкны үйлчилгээний шимтгэл, туслах үйлдвэрлэлийн, үндсэн ба биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын, найдваргүй авлагын зардал зэрэг зардал орно.
- **Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз:** Гадаад валютаар илэрхийлэгдсэн өглөг, авлага, гадаад валютын төлөгдөөгүй зээл, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн ханшийн тэгшитгэлийн олз, гарз, гадаад валютын төлбөр тооцооны ханшийн зөрүүний олз, гарз.
- **Үндсэн хөрөнгө данснаас хассанаы олз, гарз:** Үндсэн хөрөнгийн актлах, борлуулах, хандивлах зэрэг данснаас хасах үед түүний дансны үнэ болон данснаас хассаны орлогын зөрүүгээр тодорхойлогдоно.
- **Биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз:** Биет бус хөрөнгийг актлах, борлуулах, хандивлах болон бусад хэлбэрээр данснаас хасах үед дансны үнэ болон данснаас хасалтаас олсон орлогын зөрүүгээр тодорхойлогдоно.
- **Бусад ашиг, алдагдал:** Дээр тодорхойлсноос бусад ашиг, алдагдал хамаарна. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт ба данснаас хасах үеийн олз, гарз болон дахин үнэлсэн хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз /гарзын буцаалт/, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний олз, гарз.
- **Орлогын татварын зардал:** 0-6 тэрбум албан тавар ногдуулах жилийн орлогод 10%, 3 тэрбумаас дээш бол 600.0 сая + 6 тэрбумаас дээших дүнгээс 25 %, 0-300.0 сая хүртэлх бол 1 %, НӨАТ суутган төлөгч биш байна.

## 2. Орлого тооцоололт, орлогын дэлгэрэнгүй тайлан

Орлогын тайлангийн үзүүлэлтүүд: Ашиг

- **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг, (алдагдал). /ЗҮАТДА/:** Зогсоосон үйл ажиллагаа гэдэг нь борлуулсан эсвэл борлуулахаар төлөвлөж буй ААН-ийн бүрэлдэхүүн хэсэг. Зогсож буй үйл ажиллагааг илэрхийлэх хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгийн борлуулалтаас хүлээн зөвшөөрсөн татварын дараах олз, гарзын нийлбэрээр тодорхойлогдоно.
- **Нийт ашиг:** Борлуулалтын орлого – Борлуулалтын өртөг.
- $T\Theta A = (HA + TO + XO + HAO + \text{ЭШО} + BO)$  - бүх зардал + бусад ашиг – бусад алдагдал + олз - гарз
- $TДЦА$ , (алдагдал) =  $T\Theta A$  - Орлогын татварын зардал
- **Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) =  $TДЦА + ЗҮАТДА$**
- **Бусад дэлгэрэнгүй орлого хэсэгт:** Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү, гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү, тайлант үеийн бусад олз гарз орно. Энэ нь өссөн дүнгээр балансын эздийн өмчийн хэсэгт мөн тусгагдана.
- **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг:** Ашигтай ажилласан үед:

$$\text{Нэгж хувьцаанд ногдох ашиг} = \frac{\text{Тайлант хугацааны цэвэр ашиг} - \text{ДЭХ-ны ногдол ашиг}}{\text{Эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинэлсэн дундаж тоо}}$$

Алдагдалтай ажилласан үед:

$$\text{Нэгж хувьцаанд ногдох ашиг} = \frac{\text{Тайлант хугацааны цэвэр ашиг} + \text{ДЭХ-ны ногдол ашиг}}{\text{Эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинэлсэн дундаж тоо}}$$

**“Оч” компани**  
**Орлогын дэлгэрэнгүй тайлан**  
**2016 оны 12 сарын 31**

Үзүүлэлт	Тайлант үеийн дүн
Борлуулалтын орлого (цэвэр)	<b>1,327,500</b>
Борлуулалтын өртөг	<b>675,000</b>
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>652,500</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	<b>540,000</b>
Санхүүгийн зардал	<b>15,750</b>
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	<b>(13,500)</b>
Бусад ашиг (алдагдал) Бондын өглөг төлөлтийн олз	<b>36,000</b>
Орлогын татварын зардал	<b>33,750</b>
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>85,500</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>85,500</b>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

### 3. Өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайланд компанийн эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийн мөнгөн дүнг сүүлийн 2 жилээр зэрэгцүүлэн тайлагнана.

1. НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгын дүнгээр Хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулна.
2. Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдлын дүнг Хуримтлагдсан ашгийн залруулсан дүн дээр нэмнэ.
3. Бусад дэлгэрэнгүй орлогод дараах олз, гарзыг хамруулна.
  - Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү. Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй үнэ цэнийн бууралтын гарз, гарзын буцаалт
  - Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү. Валют хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүү
  - Бусад олз, гарз
4. Өмчид гарсан өөрчлөлтийг тухайн тайлант үед нэмж гаргасан хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан өөрчлөлтөөр тайлагнана.
5. Зарласан ногдол ашгийг Хуримтлагдсан ашгийн залруулсан дүнгээс хасна.
6. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн данснаас хасах үед дахин үнэлгээний хуримтлагдсан нэгмэгдэл дүнг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс хасаж, Хуримтлагдсан ашиг дээр нэмнэ.
7. Хуримтлагдсан ашиг  $C_2 =$  Тайлант үеийн цэвэр ашиг + Өмчид гарсан нэмэгдэх өөрчлөлт + Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн – Тайлант үеийн цэвэр алдагдал - Өмчид гарсан хасагдах өөрчлөлт - Ногдол ашиг
8. Эздийн өмчийн  $C_2 =$  Эздийн өмч  $C_1 +$  Нийт нэмэгдсэн өөрчлөлт – Нийт хасагдсан өөрчлөлт

### **3. Өмчийн өөрчлөлтийн тайлан**

Дасгал ажил: “Оч” компанийн 2016 оны нэмэлт мэдээлэл:

1. Авлагын данс зээлээр бараа материал борлуулснаас үүсдэг.
2. Өглөгийн данс бараа материал худалдан авахтай холбоотой.
3. 135000₮-ийн бонд гарган, 22500₮-г бэлнээр төлж, 157500₮-ийн өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авсан.
4. 3375ш энгийн хувьцааг нэг бүрийг 10₮-р гаргасан.
5. 500ш энгийн хувьцаа нэг бүрийг нь 8₮-р өөр халаасласан. Халаасны хувьцааг өртгийн аргаар бүртгэдэг.
6. 76500₮-ийн дансны үнэтэй бондыг төлсөн.
7. 31500₮-өөр бэлэн мөнгөөрх ногдол ашиг зарлаж олгосон.
8. Хуримтлагдсан элэгдэл дансны өсөлт 27000₮ ба тайлант хугацааны элэгдлийн зардал 54000₮
9. 67500₮-ийн анхны өртөгтэй тоног төхөөрөмжийг 13500₮-ийн гарзтайгаар худалдсан.

Хийх зүйл. **2016 оны санхүүгийн тайланг бэлтгэнэ үү.**

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Аж ахуйн нэгж, байгууллагны нэр: **ОЧ**

2016 он 12 сарын 31 өдөр төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал/ өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт Дүн
1	<b>2014 оны 12 р сарын 31- ний үлдэгдэл</b>	<b>145625.0</b>		<b>34375.0</b>				<b>198000.0</b>	<b>378000.0</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
3	Залруулсан үлдэгдэл	<b>145625.0</b>		<b>34375.0</b>				<b>198000.0</b>	<b>378000.0</b>
4	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>							<b>85500.0</b>	<b>85500.0</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт	<b>16875.0</b>	<b>(4000.0)</b>	<b>16875.0</b>					29750.0
7	Зарласан ногдол ашиг							<b>(31500.0)</b>	<b>(31500.0)</b>
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	<b>2015 он 12 сарын 31 ний үлдэгдэл</b>	<b>162500.0</b>	<b>(4000.0)</b>	<b>51250.0</b>				<b>252000.0</b>	<b>461750.0</b>

## 4.Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх нь

Санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлангууд нь аккруэл суурьт зарчмын дагуу бэлтгэгддэг бол мөнгөн гүйлгээний тайлан нь мөнгөн суурьт зарчимд үндэслэгддэг.

Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэдэг 2 арга байдаг.

- Шууд арга (Мөнгөн суурьт арга)
- Шууд бус арга(Аккруэл суурьт арга)

Мөнгөн гүйлгээний тайлан нь 3 хэсгээс бүрдэнэ.

1. **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ.** Байгууллагын эрхэлж буй үндсэн үйл ажиллагаатай холбоотой мөнгөн гүйлгээ багтана.
2. **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ.** Богино ба урт хугацаат хөрөнгө оруулалт болон эргэлтийн бус хөрөнгийн худалдан авалт, борлуулалтаас бий болсон мөнгөн гүйлгээг харуулна.
3. **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ.** Байгууллагын эзэмшигчдийн өмчтэй холбоотой мөнгөн гүйлгээ, зээлдүүлэгчдээс урт, богино хугацаагаар мөнгө зээлэх, зээл төлөх үед бий болсон мөнгөн гүйлгээг харуулна.

#### 4.Мөнгөн гүйлгээний тайлан

“Оч” компани  
**Мөнгөн гүйлгээний тайлан**  
 2016 он 12 сарын 31

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,282,5001
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	
	Даатгалын нөхөн олговроос хүлээн авсан мөнгө	
	Буцаан авсан албан татвар	
	Татаас, санхүүжилтийн орлого	
	Бусад мөнгөн орлого	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	
	Ажиллагчдад төлсөн	
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	
	Бараа материал худалдан авахад төлсөн	(717,750)
	Ашиглалтын зардалд төлсөн	
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	
	Хүүний төлбөрт төлсөн	(18,000)
	Татварын байгууллагад төлсөн	(11,250)
	Даатгалын төлбөрт төлсөн	
	Бусад мөнгөн зарлага	(490,500)
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>45,000</b>

## Мөнгөн гүйлгээний тайлан: “Оч” компани /үргэлжлэл/

2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	27,000
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	
	Хүлээн авсан хүүний орлого	
	Хүлээн авсан ногдол ашиг	
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(22,500)
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,500</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	33,750
	Төрөл бүрийн хандив	
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(40,500)
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	(4,000)
	Төлсөн ногдол ашиг	(31,500)
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(42,250)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>7,250</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>27,000</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>34,250</b>

Сангийн сайдын 2017 оны  
... дүгээр тушаалын  
3 дугаар хавсралт

Регистрийн дугаар:

Хаяг: \_\_\_\_\_

Шуудангийн хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_ Факс: \_\_\_\_\_

Өмчийн хэлбэр: Төрийн.....хувь хувийн.....хувь.

**Б**

.....-ийн  
20... ОНЫ... - Р УЛИРЛЫН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар өдөр	Гарын үсэг

Сангийн сайдын 2017 оны  
... дүгээр тушаалын  
2 дугаар хавсралт

Регистрийн дугаар:

Хаяг: \_\_\_\_\_

Шуудангийн хаяг: \_\_\_\_\_

Утас: \_\_\_\_\_ Факс: \_\_\_\_\_

Өмчийн хэлбэр: Төрийн..... хувь хувийн.....хувь.

**А**

.....-НИН  
..... ОНЫ ЖИЛИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг

Анхаарал тавьсанд баярлалаа